



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 257

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.2, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 63 дугаар зүйлийн 63.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Силвер лайт секюритиз ҮЦК” ХХК-д үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай.


2. Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгосонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Силвер лайт секюритиз ҮЦК” ХХК /Б.Намуунгэрэл/-д үүрэг болгосугай.

1/ Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, харилцагч, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллах;

2/ Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан зохих өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх;

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН